

УДК 398

DOI: 10.22162/2587-6503-2020-3-15-189-206

**Байгаль, экологийн сэдэвт монголын аман болон
орчин үеийн яруу найргийн бүтээлүүд
(= Произведения устной и современной поэзии
о природе и экологии)**

Алимаа А.¹, Цэвээндорж Д.²

¹ Институт языка и литературы Академии наук Монголии (д. 54а, пр-т Энхтайван (Мира), район Баянзурх, 13330 Улан-Батор, Монголия)
Ph.D., научный сотрудник
E-mail: alimaa_mgl@yahoo.com

² Институт языка и литературы Академии наук Монголии (д. 54а, пр-т Энхтайван (Мира), район Баянзурх, 13330 Улан-Батор, Монголия)
Ph.D., научный сотрудник

© КалмНЦ РАН, 2020

© Алимаа А., Цэвээндорж Д., 2020

Аннотация. В статье авторы затрагивают вопрос об ухудшающейся экологии в Монголии, что связано не с собственно природными явлениями, а необдуманной деятельностью человека. Согласно «Отчету о состоянии окружающей среды в Монголии. 2013–2014», составленном Правительством Монголии, изменение климата в Монголии усилилось, за последние 75 лет годовое количество осадков уменьшилось на 7 %, увеличилось использование ресурсов подземных вод, леса пострадали от пожаров, 10,5 тыс. га гобийских лесов высохли, при этом, согласно оценкам, 53 % опустынивания вызвано человеческими факторами. Улан-Батор сегодня является одним из самых загрязненных городов мира из-за чрезмерного выпаса скота, истощения полезных и редких растительных ресурсов и увеличения экологического ущерба от добычи полезных ископаемых. В связи со сказанным ученые уделяют большое внимание вопросу повышения осведомленности об утрате традиций сохранения природы и предоставления экологического знания через литературу и фольклор. Тема

защиты природы в монгольском фольклоре и мифе сводится к тому, что человек не всегда должен управлять природой и контролировать окружающую среду, а должен понимать и обращаться к природе как к живому существу. Это означает, что у людей будут естественные отношения, сбалансированная и безопасная жизнь. Одновременно с изучением традиционных знаний монголов о сохранении природы с 1990-х гг. стали появляться специальные монографические исследования. Общий вывод опубликованных книг состоит в том, что история взаимодействия монголов с природой была поистине цивилизованной. В современной монгольской литературе утвердилось направление экокритика (ecocriticism). Стихотворения монгольских поэтов, пишущих о природе, звучат как сигнал бедствия, как крик природы о помощи. В данной статье проведен анализ произведений традиционной монгольской и современной поэзии на тему сохранения природы и экологии.

Ключевые слова: природа, экология, Монголия, традиции сохранения, фольклор, литература, экопоэма, экокритика, писатели, культура

Благодарность. Исследование проведено при поддержке Монгольской Академии наук, тема проекта «Взаимосвязь произведений монгольского фольклора и литературы». Материалы статьи апробированы на Международной научной онлайн-конференции «Монголоведение в начале XXI в.: современное состояние и перспективы развития – II», проведенной при финансовой поддержке РФФИ (проект № 20-09-22004) и частичной поддержке гранта Правительства РФ (№ 075-15-2019-1879).

Для цитирования: Алимаа А., Цэвээндорж Д. Байгаль, экологийн сэдэвт монголын аман болон орчин үеийн яруу найргийн бүтээлүүд (= Произведения устной и современной поэзии о природе и экологии) // Бюллетень Калмыцкого научного центра РАН. 2020. № 3. С. 189–206. (На монг.) DOI: 10.22162/2587-6503-2020-3-15-189-206

UDC 398

DOI: 10.22162/2587-6503-2020-3-15-189-206

Mongolian folk and contemporary poems about ecology and nature environments

Alimaa A.¹, Tseveendorj D.²

¹ Institute of Language and Literature of the Academy of Sciences of Mongolia
(54a, Enkhtaivan ave., Bayanzurkh distr., Ulan Bator 13330, Mongolia)
Ph.D., Leading Research Associate
E-mail: alimaa_mgl@yahoo.com

² Institute of Language and Literature of the Academy of Sciences of Mongolia
(54a, Enkhtaivan ave., Bayanzurkh distr., Ulan Bator 13330, Mongolia)
Ph.D., Researcher

© KalmSC RAS, 2020

© Alimaa A., Tseveendorj D., 2020

Abstract. The social priorities of literature are the tribune of environmental ideology. Today, in the Mongolian literature, the direction of ecocriticism has been established. This article makes an analysis in traditional Mongolian poetry and modern poetry on the topic of nature conservation and ecology. In Mongolian folklore praise the purity of nature and the motherland. His idol of pure nature is praise and praise. But each species has its own color. The topic of nature protection in Mongolian folklore (Orthodoxy, Magtaal-praise, Tuul-epic, du-folk songs and myth) is that a person should not control and control nature but understand and convert to nature as a living creature; means that people will have a natural relationship, a balanced and safe life. Probably, there is not a single poet of Mongolia who does not address the topic of “man and nature”. Each in its own way perceives nature, and each in its own way revealing to the reader the world of nature and himself in this world. The space of the “Mongolian spirit” created by the poet is filled with natural landscapes, people, and historical memory. His ancestors and descendants, the dead and living, are called upon to preserve this space and believing that nature and civilization can exist in equal harmony, he would like to reconcile them among themselves. Therefore, the poems of Mongolian poets writing about nature sound like a distress signal, like a cry for help to nature. This is a feature. That is why Mongolian writers have initiated environmental protection measures. They stopped the construction of a chemical plant on Lake Hubsgul. The lake is the main freshwater reservoir in the world. Mongolian writers also warned that the pine forest “Tuzin Nars” was destroyed in nature every year billions of tons of waste. With such an attitude of man to nature on Earth there will soon be nothing left. There are examples of the writer C. Galsan, who planted 360 thousand trees. In this article we propose that we do not limit

the observation and conclusions about the mastery of writers to the nature of the writings, but take into account personal, mental and social changes in the environment.

Keywords: ecology, ecopoem, Mongolian oral and modern poems, ecocriticism, writers, culture, traditional heritages

Acknowledgement. Fundamental research study “An interrelation between Mongolian oral and literate works” sponsored by Mongolian Academy of Sciences. The article was presented at the international scientific online conference “Mongolian Studies at the beginning of the 21st century: Current State and Development Prospects – II”, held with the financial support of RFBR (project № 20-09-22004) and partial support of the Russian Government Grant (№ 075-15-2019-1879).

For citation: Alimaa A., Tseveendorj D. Mongolian folk and contemporary poems about ecology and nature environments. In: *Bulletin of the Kalmyk Scientific Center of the RAS*. 2020. No. 3. Pp. 189–206. (In Mong.) DOI: 10.22162/2587-6503-2020-3-15-189-206

Нэг. Монголчуудын байгаль хамгаалах үзэл санааны үндэс

Монголчууд байгаль орчноо хамгаалах олон зууны баялаг уламжлалтай. Энэ нь малчин удамтай монголчуудын аж төрж ирсэн газар нутаг, цаг уур, мал аж ахуйн өвөрмөц онцлогоос үүдэн гарчээ. Нэг талаас монгол хүний амьдралын хэв маяг, аж төрөх ёс; нөгөө талаас голлон эрхэлдэг мал аж ахуй нь байгалийн тогтоц, цаг уур, газрын хөрс, бэлчээр буюу өвс ургамал, гол ус зэргээс ихээхэн хамааралтай учир эрт үеэс байгаль орчныг сайтар танин мэдэж, хүндэтгэн харьцдаг өөрийн гэсэн угсаатны экологитой (ethnoecology) болжээ. Угсаатны экологид тухайн улс үндэстний уламжлал, шүтлэг бишрэл, амьдралын дадал хэвшил, хэм хэмжээ, ардын мэдлэг ухаан, оюуны соёл тэргүүтэн багтана. Байгаль хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах ард түмний түүхэн туршлага бүхий угсаатны экологи бүрэлдэхэд аман зохиол, домогзүй (миф)-гээс гадна бөө мөргөлийн өмнөх үе буюу язгуур шүтлэг, бөө шүтлэг, бурханы шашин тэргүүтэн томоохон нөлөө үзүүлжээ.

Монголчуудын язгуур шүтлэг, домгийн сэтгэлгээнд байгалийг шүтэх шүтлэг Тэнгэр, Газар, Ертөнцийн модны эрхэмнэлээр

илэрдгийг судлаачид онцлон тэмдэглэсэн байдаг. Жишээ нь, монголч эрдэмтэн С. Ю. Неклюдов “Хунну, Ухань нар Тэнгэр, Сар, од эрхисээс гадна Газар ...шүтдэг байв” [Неклюдов 1982: 170] гэжээ. Эртний киданчууд цагаан зүсмийн буга, нийт монголчууд гоо марал, бөрт чоно, буриад монголчууд хун шувуу, ойрад монголчууд уул шувуу гэхчлэн сүлд шүтээнээ болгодог байсан нь багалийн нэгээхэн хэсэг болсон ан амьтныг хайрлах, хамгаалах сэтгэлгээг хойч үед төлөвшүүлэх нөлөөтэй байв.

Монгол домогзүйн сэтгэлгээнд уул шүтлэг онцгой байртай. Эртний монголчуудын төсөөллөөр ертөнцийн төв цэг нь Сүмбэр уул гэж үзээд тууль, үлгэртээ “Сүмбэр уулыг дов байхад,сүүн далайг шалбааг байхад” хэмээн өгүүлсээр ирсэн. Оросын эрдэмтэн Н. Л. Жуковская монголчуудын уул шүтлэгийг авч үзээд “Уул бол тухайн орон нутгийн орон зай, газарзүйн баримжаа болохоос гадна шүтлэгийн чанартай. Газарзүйн хувьд төв цэг болсон уул, түүнийг тойрон бүрэлдэх бичил газруудын нэршил, байршил, байц зэрэг чухал ойлголт оршиж байдаг. Харин шүтлэгийн хувьд тэрхүү гол хайрханы нэр тухайн уулын нэр, цаашлаад угсаатны овгийн нэрийдэл нэр, хожмоо засаг захиргааны хуваарийн гол баримжаа болдог” [Жуковская 1988: 27] гэжээ. Монголчуудын цэцэн үгэнд “уул байвал ус байна” гэсэн хэллэг бий. Уул бол ус, хүнс, амьжиргааны олон эх үүсвэр гэдгийг амьдралын туршлагаараа ийнхүү онож хэлжээ. Тэрчлэн эртний овог аймгийнхан өвөг дээдсээ нутаглуулдаг тул тухайн уул, газар орныг шүтэх шүтлэг үүсчээ. Энэ бүхэн нь үнэндээ хүний амьдралын бодит хэрэгцээ, шалтгаанаас үүдэлтэй ажээ. Харин өнөө цагт олонхи судлаачид уул, газар усаа хайрлаж хамгаалах үзэл санааг ихэвчлэн хийсвэр сэтгэлгээтэй холбох нь түгээмэл ажиглагддаг. Ийнхүү монголчуудын нутаг орноо хайрлаж, хамгаалах сэтгэлгээ нэн эртнээс үүсчээ.

Өвөг дээдсийн онгоныг хадгалсан газар нутаг, уул хайрханаа тайж тахиx зан үйл лавширсаар тэдгээр онго сүнс нутаг орны далд эзэн, сахиус савдаг болон хувирч энэ нь бөөгийн шүтлэгийн үндэс болжээ. Бөө мөргөл нь өмнөх язгуур шүтлэг, домогзүйн сэтгэлгээг бодоход илүү нарийн, сүсэг бишрэл, сэтгэлзүй, тайлга тахилга зэрэг олон талыг хамарсан учир байгаль хамгаалах, экологийн

соёлын элементийг төлөвшүүлэхэд хүчтэй нөлөө үзүүлжээ. Учир нь хүн, байгаль, амьтан, ургамал, орчин тойрны юмсыг амьтай гэж үзэж, амьжуулж (гилоизм) ойлгодог. Амьд байгаль гэдэг ойлголт бол хүний экологийн соёлын үндэс учир бөө мөргөлийг “байгаль” шүтээнтэй шүтлэг гэж нэрлэдэг нь ийм учиртай.

Бурханы шашин дэлгэрснээр монголчуудын язгуурын болон бөөгийн шүтлэгийн ойлголт, загвар зэргийг өөрт ашигтайгаар найруулан ашигласан бөгөөд монголчуудын өвөг дээдсийн онго сүнс, бөөгийн шүтлэгийн “эзэн” нь бурхад уул овооны навдаг, шивдэг, савдаг тэргүүтэн болж, тэдгээрт зориулсан тусгай уншлага сангууд ч зохиогджээ.

Байгаль хамгаалах үзэл санаа энгийн иргэд, тэднийг захиран удирддаг төрийн бодлогын салшгүй хэсэг нь байсаар ирсэн юм. Тухайлбал, ард олны одоо ч өдөр тутамдаа хэрэгжүүлдэг аман хууль буюу цээрийн ёсны нэгээхэн хэсэг нь байгаль хамгаалах чиг агуулгатай юм. Томчууд нь хүүхэд багачуудад бүр багаас нь цээжлүүлж, ярьж тайлбарлаж өгнө. Жишээ нь,

— Шувууны өндгөн дээр сүүдрээ бүү тусга. Ээж нь голоод явчихна. Тэгвэл өндөг нь хагарч шувуу болдоггүй юм.

— Гол мөрөн, булаг шанд, усны ойролцоо бие засахыг нэн цээрлэнэ. Ус бол чандмань эрдэнэ.

— Ургаж байгаа өвс ургамал, жимс модыг тасдаж болохгүй. Шүүс нь гарсаар эх ургамал нь үхнэ гэх мэт.

Тэгвэл Монголчууд байгалийн баялаг, түүний ашиг шимийг хүртэх талаар 800 орчим жилийн өмнө хуульчлан тогтоож байсан түүхтэй. “Их засаг” болон бусад хууль журмын бичгүүд байгаль орчноо хайрлан хамгаалах зарлиг тогтоол гарган даган мөрддөг байв. “Их засаг” (1189–1206 он) хуульд: “Ус болон үнс рүү шээвэл цаазалсугай” (5-р бүлгийн 129-р зүйл) [Цэрэнбалтав, Минжин 2003: 36], усанд гараа дүрэхийг хориглож, ус хутгахын тулд ямар нэг сав суулга хэрэглэдэг байх (5-р бүлгийн 133-р зүйл 37), Өвс ногоорсны хойно газар нүхэлсэн ба гал алдаж билчээр шатаасны нэгэн гэрийхнийг алмуй (Их цаазын 5-р бүлэг. 119-р зүйл. 102-р тал) гэсэн бол Өлзийт хааны үед гаргасан “хууль цаазын бичиг” (1294 он)-т: “...хавар болоход хамгийн урьд мод тарьж суулгах

хэрэгтэй. Модыг зүй бус огтолж үл болно. Зөрчигчдийг хууль ёсоор ялласугай” гэх ба XVI зууны хоёрдугаар хагаст хамаарах “Зургаан хошууны хууль цааз”-ын бичигт: “...ус буртаглахад морь, үхэр хоёр ав. Үзсэн гэрч үхэр ав” [Ганзул; Хууль сахиулах; Батбилэг 1986: 95] гэж заасан байна. “Халх журам” хуульд Гал түймэрийн талаар онцгой заалт байх ба “Хэн хүн түймэр алдваас хэдэн хүн бөгөөс төдий торгууль төлөх, түймэр алдсан хүн өөрөө унтрааваас торгууль төлөхгүй, түймэр тавьсныг харсан хүн гэрчилбээс, түймэр гарсныг даралцсан хүмүүст шагнах, түймэр унтраах зар тараасан ч очоогүй бол торгох ба шийтгэнэ” [Халх журам 1958: 77] зэрэг заалт байсан ой хээрийн түймэр тавьсан гэмт этгээдийг цээрлүүлэхээс гадна ой хээрийн түймэр илрүүлсэн, унтраасан, түймрээс хүн, мал, эд хөрөнгө аварсан этгээдэд урамшуулах хэм хэмжээтэй хуулийн заалтыг байжээ. Жишээ нь, “Монгол-Ойрадын Их цааз”-ын 60-р зүйлд: “Нүүсэн нутгаас гал унтраавал хонь ав. Түймэрт үхэх хүнийг аварвал тав ав, Түймэр, ус хоёрт туслах гэсэн хүн үхвэл бэрхтэй ес ав, Унасан унаа нь үхвэл бэрхтэй босгож ав, Боол хүн, хуяг (нум) гаргавал нижгээд морь ав. Лоовууз, хуяг гаргавал морь хонь хоёр ав. Гэр бараа, эд таваар гаргавал морь, үхэр авч хувааж ид. Түймрээс хэдэн сүрэг мал гаргавал хоёрыг ав, цөөнөөс нэгийг ав” [Амархүү 2000: 225] гэж заасан байдаг ажээ. Энэ бүхэн дээр өгүүлсэнчлэн байгаль хамгаалах тухай монгол үндэстний онцлог бүхий угсааны экологийн соёлыг бүрүүлэн улмаар ардын аман зохиол, өнөө цагийн бичгийн утга зохиолд илэрч байдгийг өгүүлэлд хэлэхийг зорьлоо.

Нэг. Аман яруу найргийн бүтээлүүд дэх байгаль хамгаалах сэдэв

Монгол уран зохиолын эх үндэс, үндсэн хөрс суурь нь болсон аман зохиол нь тууль, үлгэр, домог, аман хууч, ардын дуу, ерөөл, магтаал, зүйр цэцэн үг, оньсого, ертөнцийн гурав гэх мэт төрөл зүйлийн хувьд арвин баялаг билээ. Эдгээрт байгаль орчин, эх нутгийн гоо үзэмж, түүний ач ивгээлд хүн, хүний аж амьдрал өөдлөн дэвжиж ирсэн, хүн-байгаль хоёр эх-хүүхэд мэт хүйн холбоотой гэдэг ойлголтыг агуулсан байдаг. Тийм учраас монгол

аман зохиолын нэгэн бүрэлдэхүүн болсон тайлга, тайхилгын шүлэг нь өндөр уул овоо, өргөн гол, амьдран буй газрынхаа далд эзэдэд хандан зохиогдсон юм. Эдгээр далд эздийн нэг нь монголчуудын зураглан бүтээсэн, бурхан хэлбэрийн анхны шүтээн нь морьд болоод Цагаан өвгөн [монголоор *ᠵаᠭан еbуген*, халх монголоор: *ᠵаᠭан öbgen*, *baγural övög*, *myalʃangin ᠵаᠭан övgön*; халимаг монголоор: *ᠵаᠭан аabu*, цагаан авга, жилийн эзэн; буриадаар: *saγaң übgen*] юм.

Цагаан өвгөнийг ойн сайхан цэцэрлэгт оршин сууж, амьтны сайн муу үйлийг тольдон сууж, уул усны эзэд савдагийг захиран суудаг гэж үздэг. Тиймээс цагаан өвгөнийг шашин судлаач Оросын эрдэмтэн О. Розенберг «ардын шашин» [Розенберг 1918: 48] гэжээ. Цагаан өвгөний зурагт зургаан мөнх зүйл буюу “мөнх сүндэрлэх уул, мөнхөд урсах рашаан, мөнхөд наслах хүн, мөнхөд наслах гөрөөс, мөнхөд наслах шувуу, мөнхөд наслах мод”-ны бэлгэдлийг дүрсэлж, газар усыг захирах бэлгэдлээр гартаа луун толгойт таяг, хөлдөө барын арьсан гутал өмсөж, жимслэг нэрт уулнаа ан амьтдаар хүрээлүүлэн суугаа байдлаар дүрсэлсэн [Дулам 1989: 180; Tucci, Heissig 1973: 44; Жуковская 1977: 33] байдаг. Монголчууд ийнхүү цагаан өвгөнийг байгалийн эзэн хэмээн төсөөлдгийн бэлгэдэл нь түүний хөрөгт буйгаар: жимс нь байгалийн баялаг, түүний үр шимийг, ногоон мод нь ургамлын аймгийг, ус нь бүхнийг тэтгэгч ус ариун рашааныг, уул хадны зураг нь хүнийг өвөртөө тэврэн ивгээгч газрыг төлөөлөх төдийгүй, хүн бол түүний дэргэд өчүүхэн амьтан гэдгийг харуулсан бол, тогоруу нь шувуудын аймаг болон урт насыг, гөрөөс нь амьтны аймаг, цэвэр ариун байдлыг тус тус бэлгэдсэн ажээ.

Дэлхийн эзэн Цагаан өвгөндөө цагаан идээ, сүү тараг, өрөм ааруул тэргүүтнийг өргөн арц хүж уугиулан түүнд зориулсан сангийн шүлэг уншина. Энэ нь:

Зээ Богд Цагаан өвгөн
Бушуу бугыг хөлөглөсөн
Бохигор таяг, шим эм
Боть дэвтэр барьсан
Буруутныг тэмдэглэн
Буянтныг тэтгэж

*Бурхан багшийн өмнө
Бошго зарлиг олгосон
Тэнгэрэгт эцэг
Тан дор магтан мөргөмү*

гэсэн аялгуут уншлага юм. Иймд монголчуудын хувьд Цагаан өвгөн бол дэлхий, байгалийн эзэн сахиусны бэлгэдэлт дүр байдаг.

Дээр өгүүлсэн бүхэн өнөө цагт байгаль, экологид ээлтэй ойлголтууд байсан бөгөөд монгол хүмүүст байгаль эхтэйгээ хэрхэн зүй зохистой харьцах үндсэн зарчим, чиг шугамыг тогтоожээ. Хэрэв байгаль дэлхийн эзэн, эздийг уурлуулж газарт том нүх ухах, гол ус бохирдуулах, мод огтлох, ургамлын үндэс сүйтгэх, амьтныг ихээр агнах, үүр ноохойг эвдэх зэргээр хилэгнүүлбэл тэр хүн зохих хариугаа хүртдэг гэсэн аман яриа олон бий. Тиймээс монгол аман зохиолд яг ийм үзэл номлолыг төлөвшүүлсэн байдаг. Тухайлбал, монгол туулийн эхэнд баатар эрийн төрсөн газар орон, түүний үзэсгэлэнт байгалийг заавал магтан дуулдаг тогтсон уламжлал бий. Энэ нь туулийн баатрын төрсөн нутгийг гоё сайхан хэмээн магтахаасаа гадна “тууль хайлах” гэдэг хэн бүхний хэлдэг зүйл биш “хатуу үйл” гэж үздэгтэй холбоотой. Учир нь үлгэр тууль хэлэхэд уул хайрханыг захирагч эзэд савдгууд хүрч ирж сонсдог хэмээн хүндэтгэлтэй хандаж туульч хүн тэдгээр асар хүчтэй, этгээд хачин төрх төлөвтэй, догшин ширүүн ааштай савдаг, навдгийг урин ирүүлсэн бол туулийг буруу зөрүүгүй, дутуу мадаггүй хэлж тэдний таашаал сайшаалыг хүртэх, ингэснээр оршин амьдарч буй ард олон, цаг улирал тэдний ивгээлд багтан, амар тайван болохын төлөө ийнхүү магтдаг ёс бий. Тухайлбал, “Нэгэн мянга таван зуун настай Мятал далай хааны хөвгүүн, баян өргөн баатар, Дайчин бага балчир гурван настай Дань хүрэл” хэмээх туульд Арван гурван Алтай, наян найман Хангайн уул нуруудыг магтаад, дараа нь ой модыг магтахдаа:

*“Харгуй хар мод нь
Хавцал дүүрэн ганхаад байдаг гэнэ л
Хар халтар хэрэм нь
Халин дүүлэн байдаг гэнэ л
Хамаг хэлийн олон шувууд*

*Үүр үүртээ хөглөн наадан
Жиргээд байдаг гэнэ л...*

хэмээгээд мөн дараа нь ус булаг, түүнд хөвөн наадагч төрөл бүрийн шувуудыг түүний дараа хөндий тал, тэнд ургадаг бут сөөг, өвс ургамал, цэцэг, энд байгаа араатан гөрөөс тэргүүтнийг, түүний дараа говийг гэхчлэн дээрээс доош, умраас өмнө зүг, томоос жижигрүүлэх зохиомжоор (composition) магтана. Жишээ нь,

*“...Аргаль, угалз нь
Мөргөлдөөд байдаг гэнэ л
Араатан гөрөөс нь
Сүлжилдээд байдаг гэнэ л
Үнэг, чоно нь
Шиншилдээд байдаг гэнэ л
Үен, зурам нь
Сагсалзаад байдаг гэнэ л
Буга, согоо нь
Урамдаад байдаг гэнэ л
Булга, минжэ нь
Халуураад байдаг гэнэ л
Бар, арслан нь
Хүрхрэлдээд байдаг гэнэ л
Бүжиг туулай нь
Хөөцөлдөөд байдаг гэнэ л” [Самдан 2015: 16]*

гэх мэтээс харахад зөвхөн энэ хэсэгт 13 зүйлийн амьтны нэрийг дуртгаж буйг олж харж болно.

Монгол ардын дуунд байгалийн сайхныг олон янзаар дүрслэхдээ жилийн дөрвөн улирлыг хүний сэтгэл, нас, юмсын үүсэл, хөгжил, хувьсалтай холбох, байгалийн юмс үзэгдлийг хараад аж төрлөө зохицуулах, ухаарч ойлгох талаар голчлон өгүүлнэ. Тухайлбал,

*“Огторгуй өндөр боловч орох хур нь түргэн
Орчлон мөнх боловч хөлбөрөх цаг нь түргэн
Цагаан хяруу унадаг нь өвөл цагийн дохио юм
Сайхан нас гажирдаг нь орчлонгийн ёс юм” [МДСТТ 1975: 156]*

хэмээдэг. Ийнхүү монгол аман зохиол, дуу, бөөгийн яруу найраг зэрэг төрөлд байгаль дэлхийн гоо үзэмжийг гагцхүү тоочин

дурдаж магтахаар хязгаарладаггүй бөгөөд одот ертөнцийг бүхэлд нь эргэцүүлсэн, гэр болсон байгаль дэлхийгээ хайрлаж хамгаалах санаа нэвт шингээсэн онцлогтой байдаг.

Хоёр. Монголын орчин үеийн яруу найрагт байгаль, экологийн сэдвийг гүнзгийрүүлсэн залгамжлал

Байгалийн зураглал (paysage) нь монгол яруу найргийн үндсэн өгүүлэмжийн нэг төдийгүй байгалийн уянга (naturalistic lyricism) болон бэхэжсэнийг Ц. Дамдинсүрэнгийн “Зугаацахаар мордсон нь”, Б. Явуухулангийн “Хар ус нуурын шагшуурга”, П. Бадарчийн “Есөн эрдэнийн орон” зэрэг гэрчилнэ. Эх нутаг, цэнхэр гарагийнхаа байгалийн гоо сайхныг магтан дуулж, түүнийг хайрлан хамгаалах үзэл санаа, сэтгэлгээг уламжлан хүлээн авсан монголын зохиолчид монгол орныхоо төдийгүй дэлхий дахины буюу хүн төрөлхтний байгаль хамгаалах үйлс, экологийн асуудлыг хөндөн бичиж иржээ.

Монголын орчин үеийн яруу найраг нь нэрт зохиолч Д. Нацагдоржийн “Миний нутаг” шүлгээс эхлэн Ц. Дамдинсүрэнгийн “Хэрлэн”, Б. Явуухулан “Вансэмбэрүү”, “Хойлог”, Б. Ахтаан “Бүргэд”, Д. Пүрэвдорж “Говийн ганц хайлаас”, С. Дашдооров “Алтан гургалдай дуугаа чагнан жиргэнэ”, Ш. Сүрэнжав “Уул талын дуулал”, М. Цэдэндорж “Байгалийн зураг, хүний хөрөг”, Д. Цэдэв “Хангал буга бидэн хоёр”, О. Дашбалбар “Хан Хэнтий уулс минь”, Т. Галсан “Мянган угалзын нуруу”, Д. Нямсүрэн “Чиний үлээх лимбэ, миний үлээх өвс, “Нэг ширхэг мод тарихад” зэрэг цөөнгүй шүлэг, найраглалд байгаль хамгаалах үзэл санаа шингэсэн байдаг.

2014 оны 8 дугаар сард БНХАУ-ын Ерөнхийлөгч Си Зиньпин Монгол Улсын ерөнхийлөгчийн урилгаар Монгол улсад албан ёсны айлчлал хийж энэ үедээ Улсын Их Хурлын индэр дээрээс монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч Дашдоржийн Нацагдоржийн¹

¹ Яруу найраг, жүжиг, үргэлжилсэн үгийн зохиолч, орчуулагч, нийгмийн зүтгэлтэн Дашдоржийн Нацагдорж 1906 оны 11 дүгээр сарын 17-нд Төв аймгийн Баян-Дэлгэр сумын нутагт ядуу тайжийн гэрт төржээ. Тухайн цагт дунд сургууль байхгүй байсан учир бие даан үсэг бичиг, тоо бодлого сурч улмаар зохиол бичих болсон байна. 1922 онд Монгол ардын хувьсгалт намд элсэж тухайн үеийн нэршлээр Зөвлөлт холбоот улс (Ленинград, 1925), Герман (Берлин, Лейпциг, 1926–29 он)-д суралцаж байв. Тэрээр 1937 оны долоон сарын 13-д нас барсан. 1966 онд түүний нэрэмжит утга зохиолын дээд шагналыг буй болгосон юм.

“Миний нутаг” шүлгийг уншсан билээ. Монголын үе үеийнхний сайн мэдэх 12 бадаг энэ шүлгийг 1934 онд бичсэн бөгөөд түүнийг уншихад Монгол орноор аялах мэт сэтгэгдэл төрдөг гэж үздэг. Дэлхийн 30 гаруй хэлээр орчуулагдсан байна.

Орос хэлээр	Англи хэлээр
“МОЯ РОДИНА”	“MY NATURE LAND»
<p>Хэнтэй, Хангай, Саяны, вставшие дугой, Хребты высоких гор, покрытые тайгой, Мэнэн, Шарга, Номин, о как вас любим мы, Монгольские барханы и холмы. <i>Мне так мила и сердцу так нужна Монголия — прекрасная страна.</i> Так много у тебя прозрачных чистых рек, Так много у тебя синеющих озёр, Что радуется им людской усталый взор, Что от воды их здоревает человек. <i>Мне так мила и сердцу так нужна Монголия — прекрасная страна.</i> Орхон и Селенга раскрыли берега, О мощных рудниках молва идёт в горах, Старинных городов нам слава дорога, Степями караван идёт из дальних стран. <i>Мне так мила и сердцу так нужна Монголия — прекрасная страна.</i></p>	<p>High stately mountains Khentei, Khangai and Soyon, Forests and thick-wooded ridges-the beauty of the North, The Great Gobi desert-the spaces of Menen, Sharga and Nomin, And the oceans of sand deserts that dominate the South; <i>This, this is my native land, The lovely country — My Mongolia.</i> The crystal rivers of sacred Kherlen, Onon and Tuul, Brooks, streams and springs that bring health to all my people, The blue lakes of Khovsgol, Uvs and Buir-deep and wide, Rivers and lakes where people and cattle quench their thirst; <i>This, this is my native land, The lovely country — My Mongolia.</i> The most beautiful rivers of Orkhon, Selenge and Khukhui, Mountains and passes-the source of metals and stone, Ancient structures and ruins of towns and fortresses, Roads and highways running to distant countries; <i>This, this is my native land, The lovely country — My Mongolia.</i></p>

Бэгзийн Явуухулангийн “Хойлог”, Б. Ахтааны “Бүргэд”, С. Дашдооровын “Алтан гургалдай дуугаа чагнан чагнан жиргэнэ”, Л. Дашнямын “Хараацай”, Ж. Саруулбуяны “Шар голын хөх тогоруу” зэрэг шүлэгт жигүүртэн шувууд, тэдгээрийг хайрлан хамгаалах, хүн шувуу хоёрын уялдааны тухай өгүүлсэн төдийгүй экологийн тэнцвэрийг хадгалах санаа нэвт шингэжээ. Тухайлбал, хойлог (*Tetraogallus altaicus* [Gebler 1836]) гэдэг шувууны мах шарханд сайн гэдгийг монголчууд эрт дээр үеэс мэдээд дайн байлдаантай тэр цаг үед хойлогийн махны шөлийг цэргүүдэд уулгадаг байжээ.

*“Шархатсан нэг нь доороо тэнхэрч
Шаналгасан шарх нь аньдаг байсан... учир
Хадтай ууланд гөрөөлсөн анчид
Хойлог шувууг харангуут агнаж
Эмийн шувууг хүйс тэмтэртэл агнаж эхэлжээ.*

*Азаар харин эр эм хойлог
Асгат ууландаа амьд үлдсэн юм
Арсгар барсгар хадтай уул нь
Эцсийн хойлгоо нууж үлджээ.
Түүнээс хойш эрингүүд улирсан ч
Түрэмгий дайны гай гамшигийг
Тоо толгой нь олишрч чадалгүй байсаар...”*

байгааг яруу найрагч Б.Явуухулан өгүүлээд,

*“Хүний амийг аврахад тустай
Хойлог шувууг хайрлаж яваарай”*

(“Хүн ард минь хямгадаж үзээрэй!”)

хэмээн захисан байна.

Монголын яруу найргийн санд ой модыг хамгаалах, сүйтгэхгүй байхаас сэргийлэн уриалсан шүлэг найраглал олон бий. Тухайлбал, Ардын уран зохиолч Д. Пүрэвдоржийн “Говийн ганц хайлаас”, Төрийн шагналт яруу найрагч Д. Төрбатын “Тужийн нарс”, Соёлын гавьяат зүтгэлтэн Ч. Дагвадоржийн “Тужийн нарс”, Д. Нацагдоржийн шагналт М. Чимидийн “Гацуур ирлээ”, Ч. Содномдоржийн “Монгол цэцэрлэгч” зэргийг дурдаж болно. Жишээ нь,

монгол орны умарт хэсэгт ургадаг нарс моднуудыг тайрч нарсан ой үндсэндээ үгүй болсонд олон зохиолч эмзэглэн энэ сэдвээр цөөнгүй бүтээл туурвисан юм. Тухайлбал, Д. Данзан “Тужийн нарс” шүлэгтээ:

*“Туждаа найгаж байсан
Тужийн нарс хаана байна?
Үлгэр домогтоо л үлдэх үү
Үндэс тоолон сэргэх үү?”*

гэж асуудал дэвшүүлсэн бол эрдэмтэн-зохиолч Ж. Саруулбуян мөн “Тужийн нарс” шүлэгтээ үүл шүргэм өндөр нарсыг хайр найргүй тайран галт тэрэгний уртын урт цуваанд ачин зөөж байгааг шүүмжилж:

*“Дүнз банз дүнгэнэн
Байшин болж сүндэрлэх гээд
Түлш түлээ хүнгэнэн
Бусад олныг дулаацуулах гээд
Тужийн нарс хөөрхий
Туждаа нүүж явна” гэж өгүүлжээ.*

Харин мод ургуулж байгаа цэцэрлэгчийг сайшааж Ч. Содномдорж:

*“Олны дэмээр зуу зуун төгөл зулзгалуулж
Оддын тоогоор түм түмэн цэцэг ургуулсан
Бурхан байгальч таныгаа өргөмөөрөө, ерөөмөөрөө
Буянтай цэцэрлэгч таныгаа хүндэлмээр ээ, хайрламаар аа”*

гэж шүлэглэжээ.

Монгол орон зэрлэг ан амьтнаар баялаг тул ангийн мах идэх, зарж борлуулах гэсэн хувийн шуналдаа автсан хүмүүс тэднийг үй олноор нь хайрлах сэтгэлгүй устгаж байгааг монголын зохиолчид ямагт эсэргүүцэн шүүмжилсээр ирсэн юм. Үүнд Т. Галсангийн “Мянган угалзын нуруу”, Д. Цэдэвийн “Хангал буга бидэн хоёр”, Н. Даваадашийн “Хан уулын нулимс” зэрэг олон арван шүлгийг дурдаж болно. Эдгээрээс С. Чулуунбаатарын “Гөрөөсний өчил” шүлэгт ээрэм талд бэлчиж байгаа зээр гөрөөсийг хээлтэй

хээлгүй, үр зулзагатай, сүргийн тэргүүн гэж ялгахгүйгээр хурдан буу барьж, хүчтэй машин хөлөглөсөн хүмүүс хөөж тамирдуулан олноор нь буудан хороож байгаа балмад явдлыг “гөрөөсийн үг” болгон амьдчилж:

*“Элчилгүй говийн уудамд хөл минь цуцаж байна
Эгишиж хатсан цээжнээс минь цус амтагдаж байна.
Үрээ гэсэн халуун сэтгэлээр сүү тээсэн амь
Үйл тавилангийн эрхээр хүчээ шавхаж явна
Араас минь хүн мангас хашиглан улайрч
Араатан мэт төмөр хүлэг зайгүй нэхнэ
Исгэрсэн сумны мөндөр шиг үрлүүд
Эрлэгийн элч тээж хажуугаар исгэрснэ
Алга дарам арьсыг минь авбал аваг
Амт муутай махыг минь идвэл идэг
Зүрхээр минь шахсан халуун цусыг ууж
Зүс царайгаа гоёвол гоёг, Хүн та
Чин үнэнийг хэлэхэд янзагахан үрдээ
Чинэсэн хөхөө эцсийн удаа хөхүүлэх юмсан...
Сүүмийх их говийн халуун элсэн дээр
Сүүн дуслууд мөр татан зурайна...
Амь шигээ хайрлах хүүтэй чинь адилхан
Алаг үр минь намайг хүлээж байна.
Үрээ гэсэн сэтгэлээр сүү тээсэн аминд
Үхэл биш хайр илгээгээч, Хүмүүс ээ!”*

гэж амьтныг энэрч өрөвдөх, хайрлан хамгаалах уриаг дэвшүүлжээ. Энэ мэтчилэн нуур ус, гол мөрний тэнцвэрт байдал алдагдаж байгааг сануулж “усгүй бол цусгүй болохтой адил. Усгүй бол хатна, цусгүй бол үхнэ” хэмээн хүн төрөлхтөнд сануулж байна. Жишээ нь, Ц. Чимэддорж Улаанбаатар хотын дундуур урсдаг Сэлбэ гол бохирдож, зарим улиралд ус нь татран бүр ширгэж үгүй болж байгаа тухай шүлэглэсэн юм. Үнэхээр ч хотын агаар, чийгшлийн тэнцвэр алдагдаж тоосжилт, дуу чимээ ихсэж байгааг судлаачид тогтоосон байдаг. Тиймээс хотжилт, хүн амын нягтшил гол усанд төдийгүй байгаль орчинд халгаатай болон хувирч байгааг:

*“...Аз жаргалын диваажин сууцны чинь паалан хананы
Асуултын тэмдэг шиг цоргоноос нулимс болон дуулалж байна”*

(Сэлбэ) хэмээн егөөдөн шүлэглэсэн юм. Энэ бол зөвхөн Улаанбаатар хотын асуудал биш бусад том хотуудад тулгарч байгаа цэвэр усны хангамжийн талаар өгүүлсэн санаа гэж болно. Тиймээс Шинжлэх ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгээс хэвлүүлсэн “Монголын орчин үеийн уран зохиолын түүх”-ийн IV боть (1980–2000)-д: “...Ц. Чимиддорж нь “Сэлбэ” шүлэгтээ байгаль орчноо хамгаалах санааг эрс зоримог, хүчтэй агаад урнаар өгүүлсэн. Тэрбээр байгалийн сэдэвт шүлэгт зонхилж байсан магтаалын болон уянгын аясыг шинжлэх ухаан, технологийн эрин үед хүн төрөлхтний анхаарлыг татаж буй байгаль орчинг хамгаалах өргөн цар хүрээтэй утга агуулгаар баяжуулж, санаагаа уран тод дүрслэлээр илэрхийлснээрээ яруу найрагт өөрчлөлт шинэчлэлтийн хандлагыг бий болгоход хувь нэмэр оруулсан юм” [МОҮУЗТ 2014: 21] гэжээ.

Гурав. Монгол зохиолчдын байгаль, экологийн төлөөх олон нийтийн үйл ажиллагаа

1980-аад оны дунд үед дэлхийн цэвэр усны нөөцийн нэг болох Хөвсгөл нуурын эрэгт фосфоритийн үйлдвэр байгуулах бэлтгэл ажил эхэлсэн үед Ц. Балдорж тэргүүтэй зохиолчид хүчтэй эсэргүүцсэнээр энэ аюулыг зогсоосон байдаг. Учр нь зохиолч Ц. Балдорж “Далай ээж цаазын тавцанд” хэмээх том нийтлэл бичиж “Үнэн” сонины (1987 оны) дугаарт хэвлүүлсний дараа монголын олон нийт дэмжсэн юм. Түүгээр ч зогсохгүй зохиолчдын санаачлан зохион байгуулсан “Байгалийн хөдөлгөөн” форумд Оросын нэрт зохиолч Валентин Распутин хүрэлцэн ирж “Хөвсгөл нуур хүн төрөлхтөнд ганц байна” гэсэн үгээ хэлсэн байдаг. Мөн ОХУ-ын химийн том үйлдвэрүүдийн утаа, тортог дээгүүр ниссэн шувууд хордсондоо гэнэт үхэтхийн унадаг, хүүхдийн өвчлөл, нас баралт өндөр болсон, уурхайгаас дэгдэх тоос тортог, шороо хүний биед маш хортой зэргийг жишээлэн өгүүлж байжээ. Тус хэлэлцүүлэгт Японы Н. Накамото, Америкийн К. Тэйлор, Оросын З. Балаян, Г. Галази зэрэг олон эрдэмтэн хүрэлцэн ирж оролцсон нь байгаль хамгаалал, экологийн тэнцвэрийг хадгалах талаар зохиолчид болон бусад сэхээтнүүд нэгдэн тэмцэж ирсний туршлага болж бай-

на. Байгаль хамгаалах олон улсын шагнал хүртсэн зохиолч П. Баярсайхан, Ш. Цэен-Ойдов, С. Пүрэв нар “Байгалийн төлөө” уг хөдөлгөөнийг өргөжүүлсэн юм.

Дүгнэлт

Нийгмийн оюун санааны тэргүүлэх чиглэл уран зохиол нь байгаль хамгаалах том индэр юм. Энэхүү өгүүлэлд байгаль хамгаалах үзэл санаа бүхий монголын уламжлалт аман зохиол, орчин үеийн шүлэглэсэн бүтээлийг задлан авч үзжээ. Мөн монголын зохиолчид байгаль хамгаалах хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж дэлхийн цэнгэг усын томоохон нөөц болсон “Хөвсгөл” нуурын эрэгт химийн үйлдвэр барихыг зогсоож, Тужийн нарс хэмээх нарсан ой сүйдсэнийг зохиолн бүтээлээрээ сануулсан туршлагыг өгүүлжээ.

Монголын уламжлалт аман зохиолд цэвэр ариун байгалийг шүтээн болгож түүнийг өргөмжлөн дуулах, магтах чиглэл давамгайл байдаг. Гэхдээ төрөл зүйл тус бүрдээ өөр өөрийн өнгө аястай юм. Магтан дуулсны цаад далд утга нь хүн байгалийг захирч, эрхшээлдээ оруулах бус харин байгалийг амьд, амьтай зүйл гэж ойлгож хандвал хүн байгалийн харилцаа зохистой, тэнцвэртэй байж, айх аюулгүй энх тунх амьдарцгаах болно гэсэн санааг өгүүлжээ.

Монголын орчин үеийн шүлэгч, яруу найрагчид байгаль хамгаалах сэдвээр аман зохиолын уламжлалд тулгуурлан олон чиглэлээр бичиж байна. Эх дэлхий, ус гол, өвс ургамал, ан амьтдыг хайрлан хамгаалах санал, үзэл бодлоо “үг” хэлбэрээр буюу амьдчилан өгүүлж, зохиомжилдог нь бусад орны уран зохиолоос ялгарах онцлог юм. Өнөөдөр монгол уран зохиолд экокритицизм (ecocriticism) тусгайлан судлах чиглэл болон тогтжээ.

Энэхүү өгүүлэлдээ бид, байгаль хамгаалах сэдэвтэй зохиол бүтээлийг зохиолчийн туурвил зүйн уран чадварт ажиглалт, дүгнэлт хийхээр хязгаарлалгүй, байгаль орчинд хандах хувь хүний болоод сэтгэлгээ, нийгэмд гарч буй эерэг өөрчлөлтийг хамруулан авч үзэх нь зүйтэй гэсэн санаа дэвшүүлж байна.

Ашигласан материал

- Ганзул — Түүхийн баримтын төвийн архивч Г. Ганзул.
Хууль сахиулах — Хууль сахиулах Их сургуулийн Онцгой байдлын сургуулийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн багш нарын бичсэн зөвлөмж.

Ном зүй

- Батбилэг 1986 — *Батбилэг Л.* Байгаль хамгаалал. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1986.
Амархүү 2000 — *Амархүү О.* Байгаль орчныг хамгаалах Монгол зан заншил, хууль цааз. Улаанбаатар: Хаан принтинг, 2000.
Розенберг 1918 — *Розенберг О.* Введение в изучение буддизма по японским и китайским источникам / сост. О. О. Розенберг. Ч. 1–2. Токио: Фак. вост. яз. Имп. Петрогр. ун-та, 1918. 368 с.
Дулам 1989 — *Дулам С.* Монгол домог зүйн дүр. Улаанбаатар, 1989.
Tucci, Heissig 1973 — *Tucci G., Heissig W.* Les religions du Tibet et de la mongolie // Traduit de l' allemand par R. Saille. Paris: Payot, 1973.
Жуковская 1977 — *Жуковская Н. Л.* Ламаизм и ранние формы религии. М.: Наука, 1977. 200 с.
МОУУЗТ 2014 — Монголын орчин үеийн уран зохиолын түүх. 4-р боть (1980–2000). Улаанбаатар, 2014.

Ашигласан бүтээл

- Байгаль эхийн дуулал. (Эмхэтгэж редакторласан А. Болат, К. Жанжаадорж, Л. Хуушаан нар). Улаанбаатар: М&D хэвлэлийн компани, 2002 он.
Балдорж Ц. “Далай ээж цаазын тавцан дээр”. “Үнэн” сонин. 1987 он. № 233.
Батбилэг. Л. Байгаль хамгаалал. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1986 он.
Цэдэн-Иш. Д. “Ардын Эрх” сонин. 1990 оны 07-р сарын 31.
Catrin Gersdorf, Sylvia. Nature in Literary and Cultural Studies: Transatlantic Conversations on Ecocriticism. Rodopi, 2006.
George B. Handley. New World Poetics: Nature and the Adamic Imagination of Whitman, Neruda and Walcott. University of Georgia Press, 2007.
Joseph Carroll. Literary Darwinism: Evolution, Humna nature and Literature. Routledge, 2004.